



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/140

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 5/03 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Ховд аймгийн ногоон хөгжлийн /2016-2026/ хөтөлбөр”, “Гурван Сэнхэр төвтэй таван од” аялал жуулчлалын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, Олон угсаатны соёлын биет болон биет бус өв, язгуур урлаг, цайны соёлыг түгээн дэлгэрүүлэх, патентжуулах, өвлүүлэн үлдээх, сурталчлах, аялал жуулчлалаас орох эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор “Цайны зам өв соёлын наадам”-ыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд “ITM-2019” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцоход шаардагдах талбайн түрээсийн зардалд зориулан 1 854 000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 1 854 000 төгрөг /нэг сая найман зуун тавин дөрвөн мянган/-ийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний жагсаалтын 5.7-д тусгагдсан арга хэмжээнээс санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /С.Гантөмөр/-д тус тус зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/140 Ch

02 00649